ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Санхүүжилтийн эх үүсвэр: Урсгал төсөв

Зориулалт: Баянхонгор аймгийн Татварын газрын байранд харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх

Хэрэгжүүлэх хугацаа: 2026 он

№	Техникийн тодорхойлолт	Тавигдах шаардлага
	Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 1950 мкв талбай бүхий албан конторын барилга, автогражийн байр, гадна талбай, хашаанд 24 цагийн харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх	Харуул хамгаалалтын үйлчилгээ, харуул хамгаалалтын үйлчилгээний хамрах хүрээ, чиг үүрэг: 1. Харуул хамгаалатын компани нь Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 7 дугаар багт байрлах Татварын газрын зоорийн болон авто граж бүхий 3 давхар 1950 мкв талбайтай объект, нийтийн эдэлбэрээс бусад манай байгууллагын гадна талбай, хашаа, өмч, хөрөнгөд 24 цагийн харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлнэ. 2. Харуул хамгаалалтын компанийн харуул хамгаалалтын ажилтан нь “Үндэсний ажил мэргэжил , албан тушаалын жагсаалт, ангилал, тодорхойлолт батлах тухай “ 2010 оны 16 дугаар тушаалаар батлагдсан жагсаалт дахь 5414 кодтой “Хамгаалалтын албаны ажилтан”-ы тодорхойлолт, гүйцэтгэх чиг үүрэгт дурьдсан болон доорхи үйлчилгээг үзүүлж ажиллана.Үүнд: 2.1 Хамгаалах объектын өмч хөрөнгийг хулгайлах, хорлон сүйтгэх явдлаас хамгаалж, байгууллагад орох гарах хэсгийг хяналтандаа байлгаж, байгууллагын гадна, дотно аюулгүй байдлын талаарх нийтэд хамаарах дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах; 2.2 Хамгаалах объектод завшөөрөлгүй нэвтрэн орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор, цонх хаалгыг шалгаж, эргэж, тойрч байх; 2.3 Хамгаалах объектод нэвтрэх дотоод ажилтаны болон гадны хүний бичиг баримтыг шалгах, гарч , орж ирж байгаа хүмүүст хяналт тавих; 2.4 Дэг журмыг сахиулах, гадна дотны аливаа эрсдэлт үйлдлээс байгууллагын эд хөрөнгийг хамгаалах, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулахын тулд гадны зочид, иргэдэд

1		шаардлага тавих; 2.5 Хамгаалах объектод үүсэх гал түймрийн болон ус, дулаан алдах гэх мэт аюул гарвал цаг алдалгүй Цагдаа, Онцгой байдал болон холбогдох бусад байгууллагуудад мэдэгдэх; 3. Монгол улсын Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүнийн нууцын тухай хуулийг мөдөж ажиллана.
2	Нэмэлт ажил	1. Шаардлагтай тохиолдолд байгууллагын дотоод үйл ажиллагаанд оролцох /тавилга эд хогшил зөөх, ачих буулгах ажил, лоц ломбо шалгах/, олон нийтийн хамарсан ажлуудад оролцох. 2. Гадна дотны цэвэрлэгээ тохижилтыг хариуцах /цас орсон үед байгууллагын үүд болон хариуцсан хэсгийн цас болон хог хаягдлыг зайлуулах, цэвэрлэгээ хийх, засаж сайжруулах/ автомашины зогсоолд байгаа авто тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, авто зогсоолын цэвэрлэгээг хариуцах